



**ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ДЭРГЭДЭХ
ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН 2025 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН
АЖЛЫН ТАЙЛАН**

2026 он

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2025 онд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг хэрэгжүүлэн, холбогдох хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журмын дагуу дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж, аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, дүгнэлт, зөвлөмж өгөх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх арга хэмжээг авч ажиллалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгж нь хууль тогтоомж, гэрээний хэрэгжилт, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалт, санхүү, төсөв, төрийн сангийн үйл ажиллагаа, төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, төсвийн байгууллагын өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгч, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн удирдлагаар ханган, тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн дагуу дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх Эрүүл мэндийн 62 байгууллага болон хөрөнгө оруулалтын 48 төсөл арга хэмжээний эрсдэлийн үнэлгээг тус тус хийсэн. Эрсдэлийн үнэлгээ, эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийн үнэлгээ, өмнөх жилийн аудитын дүн, тайлан зэрэгт үндэслэн “Дотоод аудитын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулан Эрүүл мэндийн сайдаар батлуулсан.

Дотоод аудитын 2025 оны төлөвлөгөөнд нийт 20 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаснаас санхүүгийн хяналт шалгалт 5, Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний дотоод аудит 8, гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрийн хяналт үнэлгээ, дотоод аудит 2, тусгайлсан хяналт шалгалт 6, бусад 3 нийт 24 арга хэмжээнд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 85.0 хувийн хэрэгжилттэй байна.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар нийт 8 арга хэмжээнд санхүүгийн хяналт шалгалтыг хийж зарим байгууллагыг хууль хяналтын газарт шилжүүлсэн байна.

Хоёр. Дотоод аудитын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил

Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

1. Санхүүгийн хяналт шалгалт:

- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны үйл ажиллагаанд хэсэгчилсэн санхүүгийн хяналт шалгалт;

- Хууль бус шийдвэрийн улмаас төрийн албанаас халагдсан ажилтнуудад нөхөн олговрыг хуулийн дагуу буруутай этгээдээр төлүүлсэн эсэхэд хийсэн санхүүгийн хяналт шалгалт;

2. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний дотоод аудит:

- Сэргээн засах төвийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо/-ын дотоод аудит;
- Эрүүл мэндийн төвийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо, Гачуурт тосгон/-ын дотоод аудит;
- Вакцины хяналтын лабораторийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/-ын дотоод аудит;
- Эрүүл мэндийн төвийн өргөтгөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо/-ийн дотоод аудит;
- Улсын хоёрдугаар төв эмнэлэг барилгын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/-ын дотоод аудит;
- Эрт илрүүлэг, оношилгооны төвийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/-ын дотоод аудит;
- Улсын нэгдүгээр төв эмнэлэг барилгын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/-ын гүйцэтгэлд дотоод аудит,
- Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд дотоод аудит;

3. Гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрийн хяналт үнэлгээ, дотоод аудит:

- Түлэнхийн төв байгуулах төсөл хөтөлбөрийн дотоод аудит;
- Глобаль сангийн дэмжлэгээр 2024-2025 онд хэрэгжүүлсэн ДОХ, сүрьеэгийн төслийн хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн дотоод аудит;
- Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төсөл арга хэмжээний мэдээллийн ODAMIS цахим системийн хөтлөлтөд хяналт үнэлгээ;
- “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл (P173799)”-ийн хэрэгжилтийн үр нөлөөний хөндлөнгийн үнэлгээ;

4. Бусад :

- Эрүүл мэндийн салбарын эрсдэлийн үнэлгээний тогтолцоонд дотоод аудит;
- Эрүүл мэндийн яамны дотоод хяналтын үйл ажиллагаанд дотоод аудит;
- Харьяа байгууллагын түрээсийн гэрээний хэрэгжилтэд дотоод аудитыг тус тус хийж гүйцэтгэсэн.

Төлөвлөгөөт бус хяналт шалалтаар:

- Сэтгэцийн Эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны хэвтэн эмчлүүлэх тасгийн төлбөртэй тусламж үйлчилгээнд тусгайлсан санхүүгийн хяналт шалгалт:

- Сэтгэцийн Эрүүл мэндийн үндэсний төвийн 2022-2024 оны хэвтэн эмчлүүлэх тасгийн төлбөртэй тусламж үйлчилгээнд санхүүгийн хяналт шалгалт хийж, шинжээчийн дүгнэлт гаргах;
- Хавдар судлалын үндэсний төвийн зарим үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт;
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн зарим үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт;
- Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийн зарим үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт;
- Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа “Өргөө”, “Хүрээ”, “Амгалан” амаржих газрын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт;
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн зарим үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт;
- Халдварт өвчин судлалын үндэсний төвийн зарим үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт;
- Улсын нэгдүгээр төв эмнэлгийн зарим үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Гурав. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

1. Шилэн дансны цахим мэдээлэл шинэчлэгдсэнээр Шилэн дансны нэгдсэн портал систем, Эрүүл мэндийн яамны цахим хуудсанд мэдээлэл байршуулах журмыг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/07 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан.
2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай 2025 оны 2/2019 албан тоот хүргүүлэн хяналт тавин ажилласан.
3. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хүрээнд ЭМЯам, ТЕЗ, харьяа 24 байгууллага, 2 тусгай сангийн цахим санд нийт 4,132 мэдээллийг байршуулахаас 3,897 мэдээллийг хуулийн хугацаанд, 86 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 149 мэдээлэл байршуулаагүй, хэрэгжилт 94.3 хувьтай байна.

Хяналт-шинжилгээний тайланг 2025 оны 09 дүгээр сарын 25-нд 2/4619 дүгээр албан бичгээр Сангийн яаманд, 12 дугаар сарын 05-ны өдрийн 9/5792 дугаар албан бичгээр ЭМЯ-ны харьяа байгууллагуудад 12 дугаар сарын 03-ны өдрийн Дотоод меморандумаар Төрийн захиргааны удирдлагын газарт тус тус хүргүүлсэн.